

Уулбаян сумын Засаг даргын Тамгын газрын
2021 оны 7 дугаар сарын үйл ажиллагааны тайлан

2021 оны 7 сарын 24-ны өдөр

Төрийн удирдлагын чиглэлээр:

Долдугаар сард 215 албан бичиг бүртгэгдсэн байна. Удирдлагын баримт бичгийн хувьд сумын Засаг даргын “А” захирамж – 204 батлагдсан бөгөөд хэрэгжилтийг тооцон ажиллаж байна.

2021 оны 07 дугаар сарын байдлаар шинээр төрсөн -107, үүнээс эрэгтэй – 43, эмэгтэй-64, ургийн овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр өөрчилсний бүртгэл-4, үрчлэлт-3, нас барсан-37 үүнээс эрэгтэй-13, эмэгтэй-24, гэрлэсний бүртгэл-42, цахим иргэний үнэмлэх захиалсан– 40, цахим ирэний үнэмлэх /16 нас хүрсэн шинээр авсан/ - -15, цахим иргэний үнэмлэх сунгалт хийлгэсэн– 25, 45 насны- 128, эцэг, эх тогтоолгосны бүртгэл – 13 тус тус бүртгэгдсэн байна.

Лавлагаа, гэрчилгээ дахин олголт:

Цахим үнэлэхний лавлагаа –17

Бусад лавлагаа – 19

Иргэний шилжилт хөдөлгөөн:

Аймаг, хотоос шилжин ирсэн –8 /том хүн-2, хүүхэд-6/, Сум, дүүрэгт шилжин ирсэн – 12 /том хүн-12, хүүхэд-8/, Баг хооронд шилжин ирсэн – 2 байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12 сарын 23-ний өдрийн 230 дугаар тогтоол “Улсын бүртгэлийн үйлчилгээний хөлсний хэмжээг шинэчлэн тогтоох тухай”-г олон нийтийн цахим сүлжээгээр сурталчлан таниулсан.

16 болон 25,45 насны иргэдийн судалгааг гарган утсаар холбогдон мэдээлэл өгч, хуулийн хугацаанд иргэний үнэмлэхний бүртгэлийг хөтөлж байна.

Бүртгэлийн нотлох материалуудыг 7 хоног бүр хэлтэст илгээн баталгаажуулж байна.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Эхний хагас жилийн төсөвт байгууллагуудын санхүүгийн тайланг хүлээн авч Э.тайланд шивж илгээн илгээлээ. Эхний хагас жилийн байдлаар төсөвт байгууллагууд нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж ЗГ-ын 43-р тогтоолойг баримтлан ажиллаж өр авлага үүсгэлгүй ажиллаж ирсэн. Орон нутгийн орлогын төлөвлөгөө 147,0 хувиар биелэж, нэр төрлөөр авч үзэхэд хамтран ажилах гэрээний дагуу уул уурхайгаас орох 50,0 сая төгрөг ороогүй байна.

ААНБ, төсөвт байгууллагуудын татварын тайланг хийж илгээлээ.

Худалдан авах ажиллагааны талаар

- Нийтийн халуун усны тендерт Зотол констракшин ХХК шалгарч гэрээгээ байгуулан 8-р сараас 10 сард Халуун усны барилгыг хүлээлгэн өгөх гэрээ байгууллаа.
- Замын хойт талд байгаа 4 айлын газар чөлөөлөж 36,0 мян төгрөгийг иргэдэд олгов..
- Жишиг хороололын ундны усны худагт 9,0 сая төгрөгөөр автомат төхөөрөмж /ухаалаг худаг/ байгуулах гэрээг хийж гүйцэтгэв.
- Чийрэгжүүлэлтийн танхим байгуулах тендерийг зарлаж 35,0 сая төгрөгөөр Санаа мед трейд ХХК шалгарч гэрээ байгуулах эрх олгоод байна.
- Жавхлантын багт 1500 м ЦДАШ-ын тендер зарлаж нэгч компани ороогүй тул дахин тендерийг зарлаад байна.
- ЭМТ-ын урсгал засвар УТХО-аар 35,0 сая төгрөгийн тендер зарлах зураг төсвийг хийлгүүлээд байна.

Төсвийн төслийн талаар.

2022 оны бүх төсөв байгууллагуудын төсвийн төсөл, 2023-2025 оны төсвийн төсөөлөлийг хийж аймгийн санхүү төрийн сан болон Боловсролын газар, ЭМ-ийн газарт хүлээлгэн өглөө. Ковид 19 халдварын нөөцөд 3002,0 мян төгрөгийн халдвар хамгааллын хувцас, оношлуур нөөцөлсөн. Бүх ажилчидын ээлжийн амралтын тооцоог хийж, амруулах тушаал шийдвэрийг гаргуулсан.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Байгаль хамгааллын чиглэлээр:

Хог хаягдлын чиглэлээр

Сумын төвийн өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор “Ногоон төгөл” төслийн хүрээнд цэвэрлэгээний ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд халамжийн иргэдийг татан оролцуулж 10 хоногийн хугацаанд ажиллаа. Ажиллах хүчний зардал хөдөлмөр халамжийн үйлчилгээний газраас гарсан. Хог хаягдлын гэрээг сумын аж ахуй нэгж болон уул уурхайн компаниудтай байгуулсан.

Усны чиглэлээр

2021 оны 6 сарын 23-нд Байгаль орчин, Мэргэжилийн хяналттай хамтран хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Хяналт шалгалтын хүрээнд менежментийн төлөвлөгөө болон холбогдох бичиг баримттай танилцаж, цаашид үйл ажиллагаа явуулах талаар хэлэлцэж, шийдвэр гаргасан. Ажлын хэсэгт БОАЖГ-ын дарга, аймгийн мэргэжилийн хяналтын байцаагч, сумын байгаль хамгаалагч, БОАЖГ-ын усны байцаагч, нарийн бичиг гэсэн бүрэлдэхүүнтэй оролцов.

Бусад ажлын чиглээр

Ногоон байгууламжийн модыг мал амьтдаас хамгаалах зорилгоор. Сумын төвийн ногоон байгууламжийн хашааг өндөрлөх ажил хийгдэж байна.

Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Малын үржүүлэг, бүртгэл:

Монгол улсын хэмжээнд зохион байгуулсан хагас жилийн тооллогын түүвэр судалгаааа баян багийн 37 өрх, жаргалант багийн 18 өрх, тэгш багийн 25 өрх, жавхлант багийн 13 өрх, дэлгэр багийн 17 өрх тус тус хамрагдсан ба нийт 43570 малыг тоолсон.

Бод малын ангиллалын зөөврийн зогсоолыг Зах Зээл ба Бэлчээрийн удирдлага болон Засаг даргийн тамгын газрын санхүүжилтээр худалдан авсан. Уг зогсоолыг Сүхбаатар аймгийн Хөдөө аж ахуйн газраас Уулбаян сумын Хөдөө аж ахуйн тасаг 2021 оны 07 дугаар сарын 05-ны өдөр хүлээн авсан.

Монгол улсын Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/45 тушаалыг үндэслэн Сүхбаатар аймгийн Засаг даргын А/165 дугаар захирамж “Үржлийн малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх”-н дагуу малын ээмэгний үндэсний үйлдвэр “Тэргүүн сүрэг трейд” ХХК- тай холбогдон малын 2021 оны 07сарын 08-ны өдөр гэрээ байгуулан ээмэг захиалах ажил хийгдсэн. Тус компани дараа MNS56412-2018 стандарт баримталдаг. Мал ээмэгжүүлэх, ангиллах ажлын хүрээнд нийт сумын хэмжээний хээлтэгч малын 1 хувийг, бүх хээлтүүлэгч малыг ээмэглэх. Ээмэгний санхүүгийн хувьд сумын ХАА-н тасагт өмнө захиалагдаж ирсэн ээмэгийг нэг бүрчлэн тоолж баг тус бүрээр нь гаргаж нөөцөнд байгаа эмээгийг ашиглан үлдсэн ээмэгний үүнийг малчдаас гаргаж авсан.

Хүнс, худалдаа, үйлчилгээ чиглэлээр:

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний бодит нөөцийн судалгаа 2021 оны 7 сарын 19-ны өдрийн байдлаар.

Бүтээгдэхүүний нэр	Нөөц
Гурил	16 тн
Гурилан бүтээгдэхүүн	348 ш
Будаа	265 кг
Хуурай/Шингэн сүү	350ш
Өндөг	500ш
Ургамлын тос	246ш
Төмс	340кг
Хүнсний ногоо	115кг
Элсэн чихэр	370кг
Давс	337кг
Савласан ус	292ш

Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний нөөц болон татан авалтын хомсдол үүсээгүй, хүнсний тээвэрлэлт хэвийн явагдаж байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр урьдчилан сэргийлэх хяналт тавьж хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний тээвэрлэлт, хадгалалтын горим, түргэн гэмтэж чанар байдлаа алдах, хүнсний бүтээгдэхүүнийг техникийн зохицуулалтад заагдсан горимд хадгалж байгаад хяналт тавин хоол хүнсээр, дамжих өвчин, хордлого, халдвараас урьдчилан сэргийлэх, мэргэжлийн

байгууллагаас гаргасан зөвлөмж, зөвлөгөөг цаасаар болон, цахимаар хүргэн ажиллалаа.

Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний буцаалт, татан авалтыг хууль тогтоомжийн дагуу бүртгэл хөтлөн хэрэгжүүлж буй байдалд хяналт тавин ажиллаж байна.

1.2. Түлшний нөөцийн хувьд хэвийн хомсдол үүсээгүй.

№	Байгууллагын нэр	A-80	A-92	ДЗ
1	“Байшинт Ойл” ХХК	15тн 800л	8тн 500л	11тн 300л

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн судалгааг 5-7 сартай харьцуулан харуулав.

№	Бүтээгдэхүүний нэр		2021 оны 5 сарын 25 байдлаар	2021 оны 7сарын 19 ны байдлаар
1	гурил	Дорнод дээд	35000	36000
		УБ 1-р зэрэг	36000	37000
		Дорнод 2-р зэрэг	29000	29500
2	Цагаан будаа		2500	2700-3000
3	Шингэн сүү		3500	3500-3700
4	Хуурай сүү		5000-9500	5000-10500
5	Элсэн чихэр		2500	2500-2800
6	Ургамлын тос		4800	4800-5500
7	Өндөг		700	550-700
8	Төмс		1800	1500
9	Хүнсний ногоо	Сонгино	2000	3000
		Байцаа	2000	2500-3000
		Лууван	2000	2500
		Сармис	2500	2500
10	Давс		1000-1100	1000-1500
11	Савласан ус		600-3500	800-4100

Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгээгүй байна.

Мэргэжлийн хяналтаас өгсөн хүнсний үйлдвэрлэл, худалдаа, хадгалалт, түгээлт, тээвэрлэлт, хоол үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд шалгалт хийж, хүнсний аюулгүй байдлыг хангуулах, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх,

халдвар хамгааллын дэглэмийг сахиулан, зөрчил дутагдлыг зогсоох үүрэг даалгаварыг авч, зөвлөмж зөвлөгөөг хүргэн ажиллаж байна.

Бусад ажлын хүрээнд

2021 оны 7 сарын 01 эхлэн хүнс худалдаа, хоол үйлчилгээ эрхлэгч 10 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, хавсралт хүснэгтийн дагуу нэгтгэж, илэрсэн зөрчил, авсан арга хэмжээг хяналтын чиглэл тус бүрээр гаргаж 7 хоногийн 2,4 дэх өдрүүдэд мэргэжлийн хяналтын газарт мэдээллэж байна.

Коронавируст халдвараас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журмын дагуу хүнс худалдаа, хоол үйлчилгээний газруудад 2021оны 7сарын 09-ны өдөр “түр тусгаарлах өрөө”-г бэлтгэж эмнэлгийн анхны тусламжийн иж бүрдэл, хамгаалах хувцас хэрэгсэл, (амны хаалт, нэг удаагийн халаад, бээлий, улавч, нүдний шил, малгай) асуумж хуудас, халдваргүйжүүлэгч зэрэг шаардлагатай хэрэгслийн нөөцийг бүрдүүлэн түр тусгаарлах өрөөний бэлтгэл ажлыг зохион байгуулан ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2021.07.07-ны өдрийн А/420 дугаар захирамжаар худалдаа үйлчилгээний ажиллах цагийн хуваарийг 08-22.00 цагийн хооронд тогтоон аймгийн хэмжээнд архи согтууруулах ундааг худалдан, борлуулах, түүгээр үйлчлэхийг зөвшөөрсөн учир лацадсан бүтээгдэхүүндээ бүртгэл хийн, хадгалах хугацааг шалган, лацийг тавих арга хэмжээг хэсгийн цагдаа Э.Анхбаяр хамтарч явууллаа.

- Тусгай зөвшөөрөлтэй 4 аж ахуйн нэгжийн нийт 301 бүтээгдэхүүний лацыг тавьсан.
- Бүтээгдэхүүний хадгалалт болон, хаяг шошгоны зөрүүтэй хугацаа хэтэрсэн зөрчил гараагүй.

2021.03.22-ны байдлаар 2011-2020 оны хооронд зээл авсан 30 зээлдэгчийн 248,800,000 төгрөгийн зээл олгосон байна. Бодогдсон хүү нь 13,627,342 төгрөг. Үүнээс, зээлийн хүү, алданги ороод 115,442,314 төгрөг эргэн төлөгдсөн. Нийт үлдэгдэл 146.625.028 төгрөг байна.

Зээлийн хэлбэр	Зээлдэгч	Зээлийн дүн
Хэвийн зээл	10 зээлдэгч	70,000,000
Эргэлзээтэй зээлтэй	/181-360хоног/ 5 зээлдэгч	47,000.000
Муу буюу чанаргүй зээлтэй	/360≥/ - 15 зээлдэгч	131,800,000

Хаагдсан зээл	7 зээлдэгч	48,287,470,
---------------	------------	-------------

2.1.1. Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийн хувь 2021 оны 6 сарын байдлаар 73,4 % байна.

- 6 сарын 30 байдлаар зээлийн эргэн төлөлтөөр 13,268,298,00 төгрөг сум хөгжүүлэх санд орж ирсэн байна.

Зээл хаагдсан 3 зээлдэгчид

	Зээл авсан он	Зээлдэгч	Зээлийн дүн
1	2011.01.08	Ц.Эрдэнэмох	6,833.000
2	2013.04.01	Г.Мөнхтулга	2,000,000
3	2013.04.01	Г.Галбадрах	7,000,000

2.1.2. Эргэн төлөлт хийхгүй байгаа зээлдэгч:

	Зээл авсан он	Зээлдэгч	Зээлийн дүн
1	2019.05.25	Л.Мөнхнаст	9,000,000
2	2020.5.27	Э.Эрдэнэтуяа	5,000,000
3	2020.05.27	А.Отгонхүү	8,000,000
4	2020.5.27	Т.Чулуун	15,000,000

Барьцаа хөрөнгийн асуудалтай 1 зээлдэгч:

- 2013 онд зээл авсан - Ж.Мөнхтуул

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлэх 1 зээлдэгчид:

- 2016 онд зээл авсан - С.Шарав

Мал эмнэлэгийн чиглэлээр:

2021 оны 06 сарын 21 нд аймгийн Мал эмнэлгийн газрын лабораториос зохион байгуулсан шүлхий өвчний вакцинжуулалтын дараах тандалтын цахим сургалтанд мал эмнэлгийн тасгийн 2 мэргэжилтэн тандалтанд ажиллах 1 малын эмч хамрагдаж тандалт хийх дээж материал цуглуулах заавар зөвлөмж авсан.

2021-06-30 нд аймгийн Мал эмнэлгийн газрын дарга М.Молорчимэг, Мал эмнэлгийн албаны дарга С.Мөнхэрдэнэ, мал эмнэлгийн улсын байцаагч Г.Мөнхзул нар ирж сумын мал эмнэлгийн тасаг, хувийн хэвшлийн мал эмнэлгүүдэд төлөвлөгөөт шалгалт зохион байгуулсан бөгөөд мал эмнэлгийн тасгийн ажлын талаар үйл ажиллагаа хэвийн байна гэж үзсэн.

Аймгийн мал эмнэлгийн газарт 2021 оны 07 сарын 03 нд шүлхийн вакцинд хамрагдах өвчлөмтгийн бүх малын тоог гаргаж хүргүүлсэн.

2021 оны 07 сарын 09 нд шүлхий өвчний ттандалтын дээж материалыг авч аймгийн лабораторид дагалдах бичиг баримтыг хавсарган хугацаанд хүргүүлсэн.

Мөн өдрийн 17.00 цагаас сумын иргэний мэдээллийн танхимд сумын Засаг дарга, багийн Засаг дарга нар малын эмч нартай уулзаж гоц халдварт шүлхий тарилга хийхтэй холбогдуулан тарилгын ажлыг зохион байгуулах, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн хүрээнд хэн хэн ямар үүрэгтэй оролцох талаар зөвлөмж өгч ажиллаа.

Малын гоц халдварт шүлхий өвчний тарилгыг зохион байгуулахад сумын Засаг даргын 2021 оны 07 сарын 07-ны өдрийн А/95 тоот захирамж гарган ажиллаа.

2021 оны 07 сарын 21 ний өдөр сумын Засаг даргын орлогч Х.Баттөр, мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч Ж.Соёлсүх багийн Засаг дарга нар шүлхий өвчний тарилгын ажлын явцанд үзлэг тандалтын ажлаар хөдөөгийн 4 багийн малчид тарилга хийж байгаа малын эмч нартай уулзаж санал бодлыг нь сонссон. Малын эмч нарын зүгээс тарилгын эхний үед баяр наадмын амралтын өдрүүд таарсан учраас малчид аялал зугаалгаар их явсан байсан хүндрэл гарснаас өөр ямар нэгэн хүндрэл гараагүй гэж мэдээлсэн. Тарилгын ажил 95% тай байна.

Нийгмийн даатгал:

Нийгмийн даатгалын шимтгэлд нийт 330016,7 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлээ.

Үүнээс:

- Ажил олгогчоос шимтгэлд -282266,3 мян төг
- Сайн дурын даатгалын шимтгэл- 37479,3 мян төг
- ЭМДаатгалын шимтгэлд- 10271,1 мян төг орлоо.

Хэлтсээс 735000.0мян төгрөгийн санхүүжилт авч 450 тэтгэвэр авагчдад 1132588,5 мян төгрөгийн тэтгэвэрийг олголоо.

СДДаатгалд 156 даатгуулагчидтай шинээр гэрээ байгуулан 37479,3 мян төгрөгийн шимтгэл , Эрүүл мэндийн даатгалд 150 даатгуулагчийг даатгаж 10271,1 мян төгрөгийн шимтгэл төвлөрүүлсэн.

Шинээр өндөр насны тэтгэвэр -24, тахир дутуугийн тэтгэвэр-2, тэжээгчээ алдсаны тэтгэвэр -2 нийт 28 тэтгэвэр, 2 тэтгэвэр авагчийн тэтгэвэрийг өөрчлөн, 7 даатгуулагчдад ажилгүйдлын тэтгэмж тогтоогоод байна.

Оршуулгын тэтгэмж 12 тэтгэвэр авагчдад 12000.0 мян төгрөг жирэмсэн амаржсаны тэтгэмжинд 15 даатгуулагчдад 23169,8 мян, Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж 5 даатгуулагчдад 312,3 мян төгрөгийн тэтгэмжийг тус тус олголоо.

2020 оны харилцах, тооцооны хуудас тайлан, зогсоогдсон тэтгэврийн хувийн хэргийг архивлан нийгмийн даатгалын хэлтэст хүлээлгэн өгөв.

Тус хугацаанд тэтгэвэр тогтоолгох өргөдөл-28 ,тэтгэвэр авах зөвшөөрөл-5, Банк солих-2 , тэтгэмж-20, ажилгүйдлын тэтгэмж-7 малчнаар ажилласан жил тогтоолгох-6 нийт 68 өргөдлийг хүлээн авч бүрэн барагдуулж , 460 иргэнд нийгмийн даатгалын үйлчилгээг хүргээд байна.

Эрүүл мэндийн төв:

Үзлэгийн мэдээ 2021 оны 07 –р сарын 23 ны байдлаар

	Нэрс	Тоо
1	Урьдчилан сэргийлэх үзлэг	1217
2	Амбулаторийн үзлэг	890
3	Идэвхтэй хяналт	39
4	Гэрийн эргэлт	80
5	Гэрийн дудлага	161
6	Алсын дуудлага	99
7	Артерийн даралт	560
8	Чихрийн шижин	692
9	Хөхний үзлэг	377
10	Эсийн шинжилгээ	58
11	0-2 насны хүүхдийн урьдчилан сэргийлэх тарилга	162
12	Ковид-19 дархлаажуулалт вакцинд хамрагдсан	18 2-р тун 3243, Пейзер вакцин - 16-17 нас, жирэмсэн, архаг хуучтай-246 иргэн хамрагдаад байна.
13	Түргэвчилсан тест	752
14	ПГУ шинжилгээ	254

15	Гэрийн тусгаарлалт, ажиглалтад байгаа	0
16	Гэрийн ажиглалтад байгаа	0

Ерөнхий боловсролын сургууль :

Амраагүй ажилчид ногооны талбайн хүсний ногоо болон сургуулийн хашааны мод зүлгийг арчилж тордлоо.

2. Их засварыг материалыг сангийн яамны программд захирал шивж орууллаа.
3. Захирал нябо нар 2022 оны төсвийн төслийг заасан хугацаанд боловсруулж илгээв.
4. Хөдөө орон нутагт ажилласны нэмэгдэл авах 10 багш, тэтгэвэрт гарах 1 ажилтны тэтгэмжийн материалыг хугацаанд нь системд оруулав.
5. Мэргэжлийн хяналтын байцаагчийн шаардлагын дагуу дотуур байрын барилгын ажлын дутууг гүйцэх ажлын хэсэгтэй хамтран ажиллалаа.

Хүүхдийн цэцэрлэг:

- Орон нутгийн 5.400.000 төгрөгийн дэмжлэгээр цэцэрлэгийн гадна, дотор талд “Гүүдвэй ложистик”ХХК-аар бүрэн камержуулалт суурилууллаа.
- 2022 оны төсвийн төслийг цахим системд шивэх ажлыг няботой хамтран хийж гүйцэтгэлээ.
- Байгууллагын хашаан дах болон нийтийн эзэмшил талбайд тарьсан модоо багш, ажилчид хуваарийн дагуу усалгаа, арчилгааг нь хийж байна.
- Байгууллагын гадна талд ариутгал халдваргүйтгэлийг 1 удаа хийж гүйцэтгэлээ.

Хууль, эрх зүйн чиглэлээр:

Аймгийн Засаг даргын 2021 оны А/343 дугаар захирамж “Сүхбаатар аймгийн бодлогын баримт бичгийн хэрэжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д нийцүүлэн сумын Засаг даргын 2021 оны А/71 дүгээр захирамж “Төсөвт байгууллагын, мэргэжилтнүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх журам” баталсан. Тус журмын дагуу төсөвт байгууллага, мэргэжилтнүүдийн хагас жилийн үйл ажиллагааг дүгнэж, үнэлсэн.

“Сумын Засаг даргын Тамгын газрын дүрэм”, “Хөдөлмөрийн дотоод журам” /шинэчилсэн/, “Цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах тухай журам” зэрэг төслийг боловсруулж, Засаг даргаар хянуулаад байна.

Тамгын газрын албан хаагчдын албан хэрэгцээнд зориулсан “Эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл” нэртэй нэн шаардлагатай 40 хууль, тогтоол, дүрэм, журмыг багтааж багцалсан гарын авлагыг бэлтгэж, Засаг даргаар хянуулаад байна.

Иргэдээс ирүүлэх өргөдөл, гомдол, санал хүсэлт, мэдээллийг түргэн шуурхай хүлээн авч, шийдвэрлэх зорилготой тусгай дугаарын 98514040 дугаарыг ажиллуулж байгаа өргөдөл, гомдол хүлээн авч байна. Мөн “Уулбаян сумын Засаг дарын Тамгын газар” гэсэн хаягтай бөгөөд цахимаар өргөдөл, гомдол хүлээн авч байна.

Сумын Засаг даргын 2021 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн А/44 дүгээр захирамжаар “Гэрийн тусгаарлалт, ажиглалад байгаа иргэдэд хяналт тавих ажлын хэсэг” байгуулан хэсгийн ахлагчаар хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн ажиллаж байна. Тус ажлын хэсэг нь гэрийн тусгаарлалт, ажиглалтад байгаа иргэдэд зөвлөмж, баталгаажилтын хуудас, хууль, дүрмийг бэлтгэн өгч, өдөр бүр ярьж биеийн байдлыг үзэж байна. 2021 оны 07 дугаар сарын 24-ны байдлаар гэрийн тусгаарлалт, ажиглалтад иргэн байхгүй байна.

2021 оны 07 дугаар дугаар сарын байдлаар Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг-1, Хүний эрүүл мэндэд гэмтэл учруулах -2, замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих-5 тус тус гэмт хэрэг, зөрчил гарсан байна.

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

ХУУЛЬ, ЭРХ ҮЙН МЭРГЭЖИЛТЭН

Л.ДАШБАЛЖИННЯМ